



МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтад ““төсөв” гэж төрийн болон орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогцыг” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.9 дэх заалтад “Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн намрын ээлжит чуулганаар хэлэлцэн 11 дүгээр сарын 15-ны дотор батлах” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг Монгол Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль тогтоомжид 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэн хүлээн авсан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 29-ны чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцээд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль тогтоомжийг хүчингүй болгосон ба үүнтэй холбогдуулан “Хууль тогтоомжийг хүчингүй болгосонтой

холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсан. Уг тогтоолоор Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Иймд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт баталсан хууль тогтоомжид бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авсантай холбогдуулан Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж нь Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

“Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй, хурдтай шийдвэрлэхэд чиглэсэн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг Улсын Их Хурал баталсан нь шинэ 30 жилийн хөгжлийн гараа, нийгэм, эдийн засгийн реформын эхлэл болж байна.

Монгол Улсын Засгийн газар хөгжлийн бодлогын баримт бичигт туссан төсөл, арга хэмжээ болон салбаруудын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг дунд, урт хугацаанд тогтвортой хадгалахаар зорьж байна.

Ирэх 2025 он нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх гарааны бүтэн жил учраас эдийн засгийн хамгийн тулгамдсан, хугацаа шаардсан суурь асуудлуудыг шийдвэрлэж эхлэх, бүсчилсэн хөгжлийн цогц реформын эхний шатыг хэрэгжүүлэх, нийслэлийн төвлөрлийг задлах зэргээр олон жил ужгирсан асуудлуудыг дорвитой шийдвэрлэхэд чиглэснээрээ онцлог жил болж байна. Энэ хүрээнд 2025 оны төсвийн бодлого бүхэлдээ хөгжлийн том төслүүдийг эхлүүлэх, төрийн оролцоог багасгаж, хувийн хэвшлийг дэмжихэд чиглэнэ. Үүнд:

1. Хөгжлийн хөрөнгө оруулалт, бүсийн томоохон дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлнэ.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлого болон “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т туссан бүсүүдийн авто зам, эрчим хүч, дэд бүтцийн хөгжлийн бүтээн байгуулалтуудыг санхүүжүүлэхэд улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл, тусламжийн санхүүжилтийг чиглүүлнэ. Тус хөгжлийн төслүүдийн үр дүнд эдийн засгийг хязгаарлаж буй хүчин зүйлсийг шийдвэрлэж, хөдөө орон нутагт гадаад дотоодын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт нэмэгдэж, бизнес эрхлэх орчин нөхцөл, амьдралын чанар эрс сайжирч, эдийн засаг, нийгмийн зорилтууд хангагдах суурь болох юм.

2. Бүсчилсэн хөгжлийн зорилттой уялдсан татварын бодлого хэрэгжүүлнэ.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан бодлоготой уялдуулан бүсүүдийг төрөлжүүлэн хөгжүүлэх татварын ялгаатай бодлогыг ирэх оноос эхлэн хэрэгжүүлж эхэлнэ. Бүсчилсэн хөгжлийн бүтээн байгуулалтын ажлыг зөвхөн улсын төсвийн эх үүсвэрээр хийх боломжгүй тул хувийн хэвшлийг урамшуулан идэвхжүүлэх бодлого баримтлах нь зүйтэй байна. Иймд бүсийн тэргүүлэх чиглэлд нийцсэн томоохон төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалт хийхийг сэдэлжүүлсэн, урамшуулсан татварын багц дэмжлэгийг үзүүлэх болно.

3. Төрийн өмчит компанийн шинэчлэл эхлүүлж, засаглал, үр ашгийг сайжруулна.

Төр аж ахуйн шинжтэй бизнесийн үйл ажиллагааг хувийн хэвшилтэй зэрэгцэн эрхэлж, тэдэнтэй өрсөлдөх, зах зээлийг хувааж байгаа одоогийн тогтолцоог өөрчилж, төрийн болон орон нутгийн өмчийн бодлогыг сайжруулах, засаглалыг олон улсын зарчимд нийцүүлэн хуулийн этгээд болон төрийн өмчийн хөрөнгийн удирдлага, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох цогц шинэчлэлийг эхлүүлж байна.

4. Боловсруулах үйлдвэрийг татварын бодлогоор дэмжинэ.

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд Засгийн газраас 2030 он гэхэд боловсруулах салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэлхийн брэндийн түвшинд хөгжүүлэн, боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байгаа ба өнгөрсөн жилүүдэд хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг түлхүү дэмжиж байсан. Цаашид эдийн засгаа төрөлжүүлэх алхмуудыг хийж, бүх төрлийн боловсруулах үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэн импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих шаардлагатай байна.

5. Үндэсний баялгийн сангаар дамжуулан үндэсний орон сууцжуулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, хот хөдөөгийн сэргэлт, төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд Үндэсний орон сууцны корпорацыг байгуулж иргэдийг орон сууцжуулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөлд 2025 оны төсвийн жилд төвлөрүүлэх нийт орлого, зарцуулах хэмжээ, хөрөнгө ба өрийн удирдлага, улс болон орон нутгийн төсөв хоорондын татаас, шилжүүлэг болон бусад зохицуулалттай холбогдсон харилцааг тусгасан 4 бүлэг, 21 зүйл, 3 хавсралттай байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн нийтлэг үндэслэл, хуулийн зорилт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль тогтоомжийн тухай;

Хоёрдугаар бүлэгт Монгол Улсын 2025 оны төсвийн орлого, зарлага болон хөрөнгө, өрийн удирдлага, Монгол Улсын төсөвт 2025 оны төсвийн жилд ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээ, төсвийн ерөнхийлөн захирагчдын Монгол Улсын төсөвт 2025 онд эргэн төлөх төлбөр, 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах төсөв, эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олгох санхүүжилт, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн зардлын хэмжээ, Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд санхүүжүүлэх "Барих-Шилжүүлэх" концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид олгох эргэн төлөлтийн хэмжээ, Төсвийн тогтворжуулалтын санд 2025 оны төсвийн жилд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, 2025 оны төсвийн жилд төсвийн алдагдлыг санхүүжүүлэх Засгийн газрын хийх гадаад, дотоод зээллэгийн дээд хэмжээ, Засгийн газрын авч ашиглах гадаад төслийн зээлийн дээд хэмжээ, 2025 оны төсвийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэй гаргасан зээллэг болон өрийн зохицуулалтын арга хэмжээнээс бусад 2025 оны төсвийн жилд төлөх Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийн хэмжээ, Засгийн газрын гаргах өрийн баталгааны дээд хэмжээ, Засгийн газраас Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, "Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг"-т нийцүүлэн хэрэгжүүлэх өрийн зохицуулалтын үйл ажиллагааны талаар;

Гуравдугаар бүлэгт орон нутгийн төсөвт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх орлого, орон нутгийн хөгжлийн санд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс олгох орлогын шилжүүлгийн талаар;

Дөрөвдүгээр бүлэгт Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт, Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх "Барих-Шилжүүлэх" концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн эргэн төлөлтийн жагсаалт болон хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 онд хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ болон Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн хуваарилалт ба санхүүжилтийн эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн зарим зүйл, хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Соёлын тухай хуулийн зарим хэсэг, заалт хүчингүй болсонд тооцох тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай, Засгийн газарт чиглэл өгөх тухай, Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулна.